



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/3/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын

менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

᠘᠘᠘᠘: ᠒᠘.᠒᠒ № 1᠒᠐
танай _____-ны № _____-т

БЯЯНДУН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ХИШИГТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баяндун сумын Засаг даргын тамгын газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 83.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021221

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	203,759,189.85	268,240,108.27
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	612,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	612,000.00
31110	Төгрөг		612,000.00
33	АВЛАГА	446,174.00	611,127.00
335	Бусад авлага	446,174.00	611,127.00
3351	Байгууллагаас авах авлага	446,174.00	611,127.00
35	БАРАА МАТЕРИАЛ	203,313,015.85	267,016,981.27
351	Түүхий эд материал	49,669,417.28	49,651,173.26
35110	Тусгай зориулалттай материал	4,036,905.00	4,036,905.00
35130	Эм боох материал	45,632,512.28	45,614,268.26
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6,861,100.00	6,861,100.00
354	Хангамжийн материал	31,186,690.57	94,908,900.01
35410	Бичиг хэргийн материал	3,970,095.00	4,590,825.00
35420	Аж ахуйн материал	24,075,575.57	23,876,362.01
35430	Сэлбэг хэрэгсэл	663,200.00	-
35440	Түлш, шатах тослох материал	1,225,060.00	-
35450	Барилгын засварын материал	1,252,760.00	952,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	65,489,713.00
35600	Мал амьтад	115,595,808.00	115,595,808.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,473,813,972.77	1,539,371,673.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,473,813,972.77	1,539,371,673.55
392	Биет хөрөнгө	1,371,271,047.85	1,439,845,548.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	634,792,989.36	659,957,900.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,766,103.51)	(130,073,515.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,084,800.00	106,053,910.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(57,721,599.88)	(68,237,399.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	282,579,334.80	252,125,144.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,656,705.37)	(106,576,181.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,060,307.50	46,752,211.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,174,595.10)	(27,577,540.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	570,273,765.00	634,882,557.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(138,131,741.59)	(179,949,600.35)
39214	Бусад үндсэн хөрөнгө	276,804,181.00	362,352,090.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(95,873,584.36)	(109,864,026.88)
393	Биет бус хөрөнгө	102,542,924.92	99,526,124.92
39301	Програм хангамж	3,662,200.00	2,467,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,175,275.08)	(1,597,075.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	108,256,000.00	108,256,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(7,200,000.00)	(9,600,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,677,573,162.62	1,807,611,781.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	446,174.00	611,127.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	446,174.00	611,127.00
413	Өглөг	446,174.00	611,127.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	446,174.00	-
4136	Бусад өглөг	-	611,127.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	611,127.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,677,126,988.62	1,807,000,654.82
51	Засгийн газрын хувь оролцоо	1,677,126,988.62	1,807,000,654.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	649,935,015.24	649,935,015.24
512	Хуримтлагдсан үр дүн	584,831,406.19	714,705,072.39
51210	Өмнөх үеийн үр дүн	584,831,406.19	584,831,406.19
51220	Тайланг үеийн үр дүн	-	129,873,666.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,360,567.19	442,360,567.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,677,573,162.62	1,807,611,781.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	660,048,204.00	436,228,546.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,508,147.00	116,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	195,508,147.00	116,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,508,147.00	116,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	703,900.00	116,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	194,804,247.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,540,057.00	436,112,446.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,231,957.00	30,104,346.00
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс гухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,607,680.00	7,563,078.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,157,577.00	22,541,268.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	466,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	383,308,100.00	406,008,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,308,100.00	406,008,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	563,844,345.89	556,083,797.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	534,720,845.89	526,613,146.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,042,510.73	497,412,237.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,680,572.06	244,044,662.89
210101	Үндсэн цалин	174,087,824.75	200,646,285.89
210104	Урамшуулал	6,383,420.00	1,722,639.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,209,327.31	41,675,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,069,791.36	31,697,730.98
210201	Тэтгэврийн даатгал	18,020,663.36	21,933,000.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,141,196.00	2,437,484.00
210203	УОМШӨ-ний даатгал	1,661,449.00	2,015,237.00
210204	Ажилгүйдлийн даатгал	384,151.00	482,904.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,862,332.00	4,829,105.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,689,861.00	15,276,898.81
210301	Гэрэл, цахилгаан	6,414,933.00	6,179,220.81
210302	Тулш, халаалт	7,274,928.00	9,097,678.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,267,761.42	43,114,004.58
210401	Бичиг хэрэг	4,256,990.00	3,549,420.00
210402	Тээвэр, шатахуун	23,356,301.00	25,117,247.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,273,000.00	2,613,500.00
210404	Ном, хэвлэл	30,000.00	2,556,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,351,470.42	9,277,137.58
2105	Нормативт зардал	1,320,845.00	660,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,200.00	-
210502	Хоол, хүнс	913,645.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	660,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,059,000.00
210604	Урсгал засвар	-	3,059,000.00
2107	Томилголт, зочны зардал	15,183,680.00	2,806,200.00
210702	Дотоод албан томилголт	15,183,680.00	2,806,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	362,904.00	13,705,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	-	12,600,000.00
210802	Хураамж	-	600,000.00
210803	Аудит, баталгаажуулалт, зэргэлэл тогтоох	52,272.00	73,200.00
210804	Даатгалын үйлчилгээ	138,800.00	60,500.00
210805	Тээврийн хэрэгслийн татвар	33,000.00	33,000.00
210806	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	150,000.00
210807	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	103,832.00	181,346.00
210808	Газрын төлбөр	35,000.00	7,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,467,095.89	143,048,194.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,024,683.00	9,679,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,442,412.89	133,368,734.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,678,335.16	29,200,909.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,833,896.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,833,896.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,844,439.16	29,200,909.32
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,844,439.16	29,200,909.32
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,123,500.00	29,470,651.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,123,500.00	29,470,651.00
220001	Барилга байгууламж	-	20,000,000.00
223001	Бусад хөрөнгө	29,123,500.00	9,470,651.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	96,203,858.11	(119,855,251.97)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	96,203,858.11	(119,855,251.97)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	465,243,957.00	436,228,546.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	703,900.00	116,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	703,900.00	116,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	703,900.00	116,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	703,900.00	116,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,540,057.00	436,112,446.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,231,957.00	30,104,346.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,607,680.00	7,563,078.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,157,577.00	22,541,268.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	466,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	383,308,100.00	406,008,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,308,100.00	406,008,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	410,015,457.00	392,159,895.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	410,015,457.00	392,159,895.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,337,121.84	362,958,985.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,522,191.07	244,044,662.89
210101	Үндсэн цалин	175,929,443.76	200,646,285.89
210104	Урамшуулал	6,383,420.00	1,722,639.00
210105	Гэрээг ажлын хөлс	28,209,327.31	41,675,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,893,853.77	31,697,730.98
210201	Тэтгэврийн даатгал	17,844,725.77	21,933,000.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,141,196.00	2,437,484.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,661,449.00	2,015,237.00
210204	Ажилгүйдлийн даатгал	384,151.00	482,904.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,862,332.00	4,829,105.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,015,263.00	15,276,898.81
210301	Гэрэл, цахилгаан	6,414,933.00	6,179,220.81
210302	Тулш, халаалт	8,600,330.00	9,097,678.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,091,842.00	34,908,037.00
210401	Бичиг хэрэг	4,675,270.00	3,365,150.00
210402	Тэвэр, шатахуун	16,695,032.00	23,892,187.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	2,608,000.00	2,588,500.00
210404	Ном, хэвлэл	538,000.00	2,755,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,575,540.00	2,306,500.00
2105	Нормативт зардал	1,320,845.00	660,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,200.00	-
210502	Хоол, хүнс	913,645.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	660,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,277,800.00	8,818,950.00
210601	Багаж, техник хэрэгсэл	6,582,000.00	3,359,950.00
210602	Тавилга	-	2,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,695,800.00	-
210604	Урсгал засвар	-	3,059,000.00
2107	Төмилөлт, зочны зардал	15,183,680.00	2,806,200.00
210702	Дотоод албан төмилөлт	15,183,680.00	2,806,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,295,104.00	13,705,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	12,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	52,272.00	73,200.00
210804	Тэврийн хэрэгслийн татвар	138,800.00	60,500.00
210805	Тэврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	932,200.00	150,000.00
210807	Газрын төлбөр	103,832.00	181,346.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	35,000.00	7,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,736,543.00	11,040,960.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,736,543.00	11,040,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,678,335.16	29,200,909.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,833,896.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,833,896.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,844,439.16	29,200,909.32
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,844,439.16	29,200,909.32
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	55,228,500.00	44,068,651.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,228,500.00	44,068,651.00
2200	Дотоод эх үүсвэрээр	55,228,500.00	44,068,651.00
220001	Барилга байгууламж	-	20,000,000.00
223001	Бусад хөрөнгө	55,228,500.00	24,068,651.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(55,228,500.00)	(44,068,651.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	649,935,015.24	442,360,567.19	584,831,406.19	1,677,126,988.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	649,935,015.24	442,360,567.19	584,831,406.19	1,677,126,988.62
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайланг үеийн үр дүн				0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	649,935,015.24	442,360,567.19	584,831,406.19	1,677,126,988.62
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	649,935,015.24	442,360,567.19	584,831,406.19	1,677,126,988.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	649,935,015.24	442,360,567.19	584,831,406.19	1,677,126,988.62
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	129,873,666.20	129,873,666.20
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	649,935,015.24	442,360,567.19	714,705,072.39	1,807,000,654.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	406,608,100.00	382,055,549.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,538,700.00	382,055,549.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,538,700.00	352,854,639.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,527,300.00	242,322,023.89
210101	Үндсэн цалин	219,039,400.00	200,646,285.89
210105	Гэрээг ажлын хөлс	45,487,900.00	41,675,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,279,200.00	31,697,730.98
210201	Тэтгэврийн даатгал	23,561,900.00	21,933,000.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,097,200.00	2,437,484.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,693,700.00	2,015,237.00
210204	Ажилгүйдлийн даатгал	539,700.00	482,904.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,386,700.00	4,829,105.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,527,500.00	15,276,898.81
210301	Гэрэл, цахилгаан	6,673,200.00	6,179,220.81
210302	Түлш, халаалт	8,854,300.00	9,097,678.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,514,500.00	26,958,650.00
210401	Бичиг хэрэг	4,474,000.00	3,300,150.00
210402	Тээвэр, шатахуун	16,307,800.00	16,107,800.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	2,559,500.00	2,488,500.00
210404	Ном, хэвлэл	2,852,700.00	2,755,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,320,500.00	2,306,500.00
2105	Нормативт зардал	660,000.00	660,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	660,000.00	660,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,037,000.00	8,818,950.00
210601	Багаж, техник хэрэгсэл	3,360,000.00	3,359,950.00
210602	Тавилга	2,450,000.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	3,227,000.00	3,059,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,330,000.00	2,806,200.00
210702	Дотоод албан томилолт	3,330,000.00	2,806,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,132,000.00	13,705,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,900,000.00	12,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	73,200.00	73,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	186,300.00	60,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
210807	Газрын төлбөр	182,000.00	181,346.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,500.00	7,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,531,200.00	10,608,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,531,200.00	10,608,640.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	29,200,909.32
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	29,200,909.32
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	29,200,909.32
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,069,400.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	24,069,400.00	-
223001	Бусад хөрөнгө	24,069,400.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,104,346.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,104,346.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,104,346.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,448,400.00
210104	Урамшуулал	1,448,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,585,978.00
210402	Тээвэр, шатахуун	6,585,978.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,069,968.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,069,968.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000,000.00
220001	Барилга байгууламж	20,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,104,346.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,104,346.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,563,078.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,541,268.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Д.Хишигт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх
- Төрийн үйлчилгээг иргэдэд онлайнаар хүргэх, төрийн албан хаагчдын цахим орчны хэрэглээг зохицуулах ажлыг зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 563,844.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,276.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 556,613.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,132.3 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,038.6 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		612.0	612.0
Авлага	446.2	611.2	165.0
Урьдчилгаа			
Бараа материал	203,313.0	201,527.2	1,785.8
Үндсэн хөрөнгө	1,473,813.9	1,604,861.3	131,047.4
Нийт хөрөнгө	1,677,573.1	1,807,611.7	130,038.6
Өр төлбөр	446.2	611.2	165.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,677,126.9	1,807,005.5	129,873.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,677,573.1	1,807,611.7	130,038.6

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 612.0 мянган төгрөгөөр өссөн нь иргэдээс цар тахалтай тэмцэхэд зориулан хандивласан бэлэн мөнгийг кассад авч төрийн сангийн дансанд тушаалгүй үлдээснээс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 611.2 мянган төгрөг болж өссөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл 611.2 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,604,861.3 мянган төгрөг болж 131,047.4 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар 244,932.8 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 19,644.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн, тайлант жилийн элэгдлийн зардал нь 133,530.3 мянган төгрөгийн болсон байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 611.2 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,807,005.5 мянган төгрөг болж 129,873.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Баяндун сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 223,819.6 мянган төгрөгөөр буюу 33.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө болон төлбөргүй шилжүүлсэн авсан хөрөнгийн хэмжээ буурснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 7,760.4 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс 17.5 хувь, хангамжийн материалын зардал 29.5 хувиар тус тус норматив зардал, нэмэгдсэн ч эд хогшил, томиллолт, бараа үйлчилгээний бусад, урсгал шилжүүлгийн зардлууд эрс буурснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 349,317.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 349,317.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 57,290.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвөөс санхүүжих 406,608.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 406,608.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 406,008.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 600.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон төсвөөс 406,608.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 377,407.2 мянган төгрөг зарцуулж, 29,200.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 377,407.2 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь цалин болон холбогдох зардлыг 24,303.6 мянга, байр ашиглалтын зардлыг 250.6 мянга,

хангамжийн материалын зардлыг 2,555.8 мянга, эд хогшлын зардлыг 218.0 мянга, томилолтын зардлыг 523.8 мянга, бусдаар гүйцэтгүүлэх бараа ажил үйлчилгээний зардлыг 426.5 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардал 922.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 7,563.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 22,541.2 мянга, нийт 30,104.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урамшууллын зардалд 1,448.4 мянга, тээвэр шатахууны зардалд 6,586.0 мянга, барилга байгууламжийн зардал 20,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2,069.9 мянган нийт 30,104.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 137 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж, нийт 437,453.4 мянган төгрөг буюу 14 мэдээлэл хуулийн хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 16,700.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 16,700.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг биелүүлэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	16,700.0	1	16,700.0	-	-	-
Зөвлөмж	1	0	1	0	-	-	-
Нийт дүн	2	16,700.0	2	16,700.0	-	-	-

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,277.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,108.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 612.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,557.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүллээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдээс мөнгөн 612.0 мянга, мөнгөн бус 2,654.0 мянга, аж ахуйн нэгжээс мөнгөн бус 900.0 мянга нийт 3,554.0 мянган төгрөгийн хандивыг орлогын тайланд, мөнгөн бус хандив болох 1,200.0 мянган төгрөгийг бараа материал зарцуулсныг зардлаар тусгаагүй байсан тул санхүүгийн тайланд нийт 4,754.0 мянган төгрөгийг залруулав.

2. Иргэд болон аж ахуйн нэгжээс хандивласан бараа материалын үлдэгдэл нийт 2,354.0 мянган төгрөгийг бараа материалын дансны эцсийн үлдэгдлээр тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар кассын үлдэгдэлтэй, санхүүгийн тайланд тусгаагүй байсантай холбоотой 612.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 437,453.4 мянга, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой 2,461.9 мянга, орлогын төлөвлөгөө тасалдуулсантай холбоотой 484.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутгасан 611.1 мянга, нийт 441,010.4 мянган төгрөгийн 4 албан шаардлага тус тус хүргүүллээ.

1. Иргэдээс мөнгөн хандиваар 612.0 мянган төгрөгийг кассын дэвтэр бүртгэснийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Сангийн Сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын I хавсралтын 3.12 дахь “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж...” гэсэн заалтууд, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Сумын Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2,461.9 мянган төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 1.2 дахь “Энэ журмын 1.1-д заасан “урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан” гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно” гэсэн заалтууд, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.

3. Тайлант онд Шилэн дансны сайтад нийт 437,453.4 мянган төгрөг 14 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т “Энэ хуулийн

3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтууд, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 611.1 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ...” гэсэн заалтууд, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

5. Тайлант онд тус байгууллага төсвийн орлогын төлөвлөгөөг 80 хувиар буюу 484.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.2 дахь “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтууд, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баяндун сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/3/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баяндун сумын ЗДТГ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Иргэдээс мөнгөн хандиваар 612.0 мянган төгрөгийг кассын дэвтэр бүтгэснийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	612.0	Төлбөрийн акт	Дарга	Д.Хишигт
2	Сумын Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөнөөс нийт 2,461.9 мянган төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна.	2,461.9	Албан шаардлага	Дарга	Д.Хишигт
3	Тайлант онд Шилэн дансны сайтад 14 мэдээлэл хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.	437,453.4	Албан шаардлага	Дарга	Д.Хишигт
4	Төсвийн орлогын төлөвлөгөөг 80 хувиар буюу 484.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.	484.0	Албан шаардлага	Дарга	Д.Хишигт
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 611.1 төгрөгийн татвар суутгасан байна.	611.1	Албан шаардлага	Дарга	Д.Хишигт
ДҮН		441,622.4			

